


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар буюу **30-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 11 аймагт **1341** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авч



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1341 тохиолдлын 95% /1270/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /71/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /4/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **374** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.


30 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.07.19 – 2026.07.25)

2026 оны гучдугаар долоо хоногт 0 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 100 хувиар, 5 жилийн дунджаас 100 хувиар тус, тус буурсан үзүүлэлттэй байна.


**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-30 дугаар долоо хоногт** нийт **1026** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **гучдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **27** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 114 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (30-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	14	6	20
2	Эмийн хордлого	4	3	7
Нийт		18	9	27

Нийт 27 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 7 (26%) нь эмийн хордлого, 20 (74%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 9 (33%) тохиолдол, санаатай хордлого 18 (67%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-o0o-